



ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Европын Хуулийн Байгууллагаас гаргасан саатуулах зөвшөөрлөөр хоригдсон буюу түр саатуулан хорих өргөдөлтэй эсвэл тус улсаас албадан гаргах өргөдөл ирсэн хүнд олгох

Таныг түр саатуулан баривчлах өргөдөл, тус улсаас албадан гаргах хүсэлт эсвэл Европын Хуулийн Байгууллагаас гарсан саатуулах тушаалын дагуу таныг баривчилсан болно. Уг баримт нь таны эдлэх гол эрхийг танд сануулж байгаа болно.

Дор дурьдагдсан мэдээллүүд таны ойлгох хэл дээр өгөгдсөн байх ёстой.

Та өөрийг саатагдах хугацаанд уг баримтыг өөртөө хадгалах ёстой

Та аль нэгэн гаднын Улсаас эрэн сурвалжилагдаж байгаа ба Европын Хуулийн Байгууллагаас гарсан саатуулах зөвшөөрлийн дагуу саатуулагдсан эсвэл албадан гаргах өргөдөлийн улмаас мөн адил ял шийтгэл эдлүүлэхийн тулд албадан гаргах өргөдлийн улмаас түр саатуулагдаж байгааг танд мэдэгдсэн.

Зөрчил хүлээх

Та өөрийн хийсэн гэх хэргийн байдал, огноо ба газар байршилийг мэдэх эрхтэй ба мөн таныг түр хорих байранд байрлуулсан шалтгаан учирьг мэдэх эрхтэй.

Өмгөөлөгчийн туслалцаа

Өмгөөлөгч сонгох

Саатуулсаны эхэнд та өөрийн эсвэл улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцаа авах хүсэлт гаргах эрхтэй. Та өөрөө өмгөөлөгчөө сонгох боломжгүй эсвэл таны өмгөөлөгч холбогдох боломжгүй бол та байгууллагаас танд туслалцаа үзүүлэхээр сонгосон өмгөөлөгчийг авах эрхтэй.

Таны урьдчилан мэдэгдсэн хүн таны өмгөөлөгчийг сонгож болно: энэ тохиолдолд та түүний сонгосон өмгөөлөгчийг батлан зөвшөөрөх ёстой.

Өмгөөлөгчийн туслалцаа ба үйлчлэх хугацаа

Өмгөөлөгч ярилцлагын нууцыг чанд хадгалсан нөхцөлд 30 минутын турш таньтай ярилцаж болно.

Таны анхны байцаалт таны өмгөөлөгч авах хүсэлт гаргаснаас хойш хоёр цаг өнгөрөхийн өмнө өмгөөлөгч байхгүй тохиолдолд эхэлж явч болохгүй, үүнд зөвхөн таны биеийн байцаалтын ярилцлага орохгүй.

Хэрэв таны өмгөөлөгч хэлэлцэгдэж буй байцаалтны дундуур ирсэн тохиолдолд уг байцаалт таны хүсэлтээр өмгөөлөгчтэйгөө ярилцах боломж олгож, танд түр завсарлаж болно.

Үг хэлэхгүй байх эрх

Түр саатуулагдах хугацаанд та мэдүүлэг өгөх, асуултад хариулах ба үг хэлэхгүй байх зэргийг сонгож болно.

Хэлмэрчийн туслалцаа

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй тохиолдолд та шүүх хурлын үед өмгөөлөгчтэй холбоо барих ба үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Эрх чөлөө хасах хугацаа ба цаашдын арга хэмжээ

Та дөчин найман цаг саатуулагдана, цаашид сунгагдахгүй.

Уг хугацаа дууссаны дараа, та газар нутгийн хэмжээнд эрх мэдэлтэй ерөнхий прокурорын өмнө хариуцлага хүлээх ба тэр таны биеийн байцаалт хийнгээ таны ойлгодог хэл дээр мөн таны нэр дээр Европын баривчлан саатуулах баримт гарсан болохыг илэрхийлж, эсвэл таныг улсаас албадан гаргах баримтыг нотлон, эсвэл таныг түр саатуулах болсныг хэлж, мөн үүний зэрэгцээгээр та өөрийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлж болох эсвэл улсаас томилдог үнэ төлбөргүй өмгөөлөгчийн туслалцаа авч болохыг танд мэдээллэнэ.

Энэ тохиолдолд та өөрийн өмгөөлөгчтэй нэн даруй ярилцаж, тэр таны хавтаст хэрэгтэй танилцаж таньтай чөлөөтэй харьцах эрхтэй.

Европын баривчлан саатуулах баримт ирсний дараа эсвэл түр хорих баримт эсвэл улсаас албадан гаргах өргөдөл ирсний дараа ерөнхий прокурор таныг суллахгүй шийдвэр гаргасан тохиолдолд та Давж заалдах шүүхийн нэгдүгээр ерөнхийлөгчийн өмнө эсвэл түүнээр томилогдсон Прокурор танд энэ талаар мэдэгдэнэ. : тэрээр

- таныг албадан гаргах баримтуудыг хүлээн автал таныг түр саатуулж болно (хугацаа нь хэлэлцээрээс шалтгаална), ба та европын саатуулах баримтат бичиг буюу албадан гаргах бичгийг хэрэгжүүлэх журмаар шүүхийн байгууллагаар хэлэлцүүлэгдэнэ.
- эсвэл, хэрэв уг байгууллага нь таны төлөөлөл ерөнхийдөө баталгаатай гэж үзвэл, та хуулийн байгууллагын хяналтанд орж, өөрийн байршилыг заан хэлэн хянуулж, цахилгаан гав зүүн эсвэл таныг таныг албадан гаргах баримтууд, эсвэл таныг тухайн улсад гардуулж өгөх шүүхийн өмнө ирэх баримт зэргийг бүрдүүлтэл хяналтгүй суллах сонголттой.

Даатгуулан гардуулахыг зөвшөөрөх боломж

Таныг эрэн сурвалжилж байгаа улсад даатгуулах эсэхийг та зөвшөөрөх ба эс зөвшөөрөх эрхтэй. Гардуулалтын тохиолдолд шүүхийн байгууллага нь богино хугацаанд шийдвэрлэх үүргийг хүлээнэ. Хэрэв та Европын Холбооны Шүүхийн Байгууллагын саатуулах баримтыг зөвшөөрч байвал цаашид таны уг шийдвэр өөрчлөгдөхгүй.

Зарим хүний талаархи мэдээлэл

Та өөрийн ойр дотнын хүмүүс, гэр бүлийн гишүүдэд өөрийн баривчлагдан саатуулагдаж байгаа талаар мэдэгдэх эрхтэй.

Хэрэв та гадаад улсын иргэн бол өөрийн улсын консулын газарт мэдэгдэх эрхтэй.

Эмчийн үзлэг

Та саатуулагдсан хугацаанд эмчийн үзлэгээр орохыг хүсэлт гаргах эрхтэй.